

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Дархан сумын 6 дугаар цэцэрлэг 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2026/66/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Дархан-Уул аймаг
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр:
Утас: 70378845
Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Ахлах аудитор: С.Батцэцэг
Утас: 70373089
Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Аудитор: Ч.Гантулга
Утас: 99372297
Цахим хаяг: tsesb.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН 6 ДУГААР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
С.БОЛОРТУЯА ТАНАА

5

2022.12.15 № 121

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын 6 дугаар цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн Дархан сумын 6 дугаар цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын өс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант хугацаанд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 10,150.0 мянган төгрөгийн зөөврийн компьютер, аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 11,926.0 мянган төгрөгийн гал тогооны тоног төхөөрөмж, Дархан сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 32,900.0 мянган төгрөгийн гадна явган хүний зам болон хүүхдийн тоглоомын талбай тохижуулах зэрэг хөрөнгүүдийг холбогдох дансанд бүртгэж, санхүүгийн тайланд толилуулж, тодруулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

4526050089

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг нэмэгдүүлснээр цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал 203,008.3 мянган төгрөг болж өнгөрсөн оны гүйцэтгэлээс 26 хувиар өссөн байна.

Бусад асуудал

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Аудитыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн хүрээнд авсан судалгаанд дүн шинжилгээ хийж, эрсдэл бүхий асуудалд анхаарал хандуулсан болно.

Дархан-Уул аймгийн Дархан сумын 6 дугаар цэцэрлэгийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 13 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 98 хувиар тайлагнасан байна. Мөн улирал бүр аймгийн Боловсролын газарт ажлын тайланг хүргүүлж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	300,350,861.75	112,974,140.54
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	244,033,308.75	23,268,504.98
312	Банканд байгаа бэлэн мөнгө	244,033,308.75	23,268,504.98
3121	төгрөг	244,033,308.75	23,268,505.98
31211	Төрийн сангийн харилцах	244,033,308.75	23,268,506.98
35	БАРАА МАТЕРИАЛ	56,317,553.00	89,705,637.56
351	Түүхий эд материал	1,078,700.00	1,078,702.00
3513	Эм боох материал	1,078,700.00	1,078,702.00
354	Хангамжийн материал	55,238,853.00	88,626,935.56
35410	Бичиг хэргийн материал	3,429,590.00	5,261,650.00
35420	Аж ахуйн материал	40,772,959.00	73,538,095.56
35460	Хүнсний материал	11,036,304.00	9,827,190.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,032,143,766.58	2,022,498,993.54
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,032,143,766.58	2,022,498,993.54
392	Биет хөрөнгө	1,781,661,336.60	1,772,280,563.56
39201	Барилга, байгууламж орон сууц	1,792,724,036.90	1,792,724,036.90
39202	Хуримтлагдсан элэгдэл	(177,274,486.38)	(215,485,977.30)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	88,975,110.00	106,833,010.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(28,724,424.83)	(36,242,801.93)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	43,606,444.85	30,874,921.85
39208	Хуримтлагдсан элэгдэл	(22,183,316.44)	(12,858,855.63)
39214	Бусад үндсэн хөрөнгө	138,411,590.15	130,636,090.15
39215	Хуримтлагдсан элэгдэл	(54,704,746.78)	(24,199,860.48)
39217	Ном	831,129.13	-
393	Биет бус хөрөнгө	250,482,429.98	250,218,429.98
39301	Программ хангамж	1,320,000.00	1,320,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(19,570.02)	(283,570.02)
39303	Бусад биет бус хөрөнгө	249,182,000.00	249,182,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,332,494,628.33	2,135,473,134.08
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	2,450,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	2,450,000.00
	Байгууллагад төлөх өглөг		2,450,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,332,494,628.33	2,133,023,134.08
51	Засгийн газрын хувь оролцоо	2,332,494,628.33	2,133,023,134.08
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	249,182,000.00	249,182,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	2,012,361,214.28	1,812,889,720.03
51210	Өмнөх үеийн үр дүн	1,904,158,854.41	2,012,361,214.28
51220	Тайлант үеийн үр дүн	108,202,359.87	(199,471,494.25)

51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	70,951,414.05	70,951,414.05
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,332,494,628.33	2,135,473,134.08

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	1,305,702,365.00	1,237,533,220.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	57,759,765.00	73,481,020.00
120	Нийтлэг татварын бус орлого	57,759,765.00	73,481,020.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн хөрөнгө	28,140,000.00	39,310,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	28,140,000.00	39,310,000.00
120009	Бусад орлого	-	2,450,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	29,410,500.00	22,076,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	209,265.00	9,645,020.00
13	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,247,942,600.00	1,164,052,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,194,455,700.00	1,109,058,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,194,455,700.00	1,109,058,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	53,486,900.00	54,993,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	53,486,900.00	54,993,500.00
2	Үйл ажиллагааны зардал	1,197,503,005.13	1,437,004,714.25
21	Урсгал зардал	1,197,503,005.13	1,437,004,714.25
210	Бараа, үйлчилгээний зардал	1,171,067,389.45	1,424,312,431.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	790,871,282.68	993,879,602.79
210101	Үндсэн цалин	549,346,006.91	639,065,786.84
210102	Нэмэгдэл цалин	204,652,670.40	276,310,487.90
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	38,619,000.00
210104	Урамшуулал	36,872,605.37	39,884,328.05
2102	Нийгмийн даатгалын шимтгэл	97,967,995.84	122,761,454.98
210201	Тэтгэврийн даатгалын	66,867,392.06	82,956,090.98
210202	тэтгэмжийн даатгалын	7,898,626.32	9,951,262.50
210203	ҮОМШӨ-ий даатгалын	3,933,713.61	4,975,631.25
210204	Ажилгүйдлийн даатгалын	3,825,630.17	4,976,046.83
210205	ЭМ-ийн даатгалын	15,442,633.68	19,902,423.42
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,571,784.32	38,766,417.28
210301	Гэрэл цахилгааны зардал	11,598,662.40	14,260,012.36
210302	Түлш, халаалтын зардал	10,557,224.92	11,239,781.52
210303	Цэвэр бохир усны зардал	11,415,897.00	13,266,623.40
2104	Хангамж, бараа материалын зардал	30,281,075.00	20,733,429.13
210401	Бичиг хэргийн зардал	351,300.00	1,468,350.00
210404	Ном хэвлэл	80,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	29,849,775.00	15,023,012.00
210406	Бараа материал акталсны зардал	-	4,242,067.13
2105	Нормативт зардал	143,275,681.00	159,498,414.00
210502	Хоол, хүнс	143,275,681.00	159,498,414.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	9,614,000.00
210604	Урсгал засварын зардал	-	9,614,000.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлс	3,091,112.00	2,841,436.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	3,091,112.00	2,841,436.00
2109	Бараа, үйлчилгээний бусад зардал	72,008,458.61	76,217,677.35
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,901,256.00	8,652,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	64,107,202.61	67,564,877.35
213	Урсгал шилжүүлэг	26,435,615.68	12,692,282.72
	Бусад урсгал шилжүүлэг	24,020,500.00	9,465,200.00
	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	24,020,500.00	9,465,200.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,415,115.68	3,227,082.72
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,415,115.68	3,227,082.72
3	Үйл ажиллагааны үр дүн	108,202,359.87	(199,471,494.25)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,247,942,600.00	1,166,502,200.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	2,450,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	2,450,000.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	-	2,450,000.00
120009	Бусад орлого	-	2,450,000.00
13	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,247,942,600.00	1,164,052,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,194,455,700.00	1,109,058,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,194,455,700.00	1,109,058,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	53,486,900.00	54,993,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	53,486,900.00	54,993,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,133,965,484.52	1,385,867,203.77
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,133,965,484.52	1,385,867,203.77
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,107,529,868.84	1,373,174,921.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	790,871,282.68	993,879,602.79
210101	Үндсэн цалин	549,346,006.91	639,065,786.84
210102	Нэмэгдэл	204,652,670.40	276,310,487.90
210103	Хоол унаа хөнгөлөлт		38,619,000.00
210104	Урамшуулал	36,872,605.37	39,884,328.05
2102	Ажил олгогчийн нийгмийн даатгалд төлөх шимтгэл	97,967,995.84	122,761,454.98
210201	Тэтгэврийн даатгалын	66,867,392.06	82,956,090.98
210202	Тэтгэмжийн даатгалын	7,898,626.32	9,951,262.50
210203	ҮОМШӨ-ий даатгалын	3,933,713.61	4,975,631.25
210204	Ажилгүйдлийн даатгалын	3,825,630.17	4,976,046.83
210205	Эрүүл мэндийн даатгалын	15,442,633.68	19,902,423.42
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,571,784.32	38,766,417.28
210301	Гэрэл цахилгааны зардал	11,598,662.40	14,260,012.36
210302	Түлш, халаалтын зардал	10,557,224.92	11,239,781.52
210303	Цэвэр бохир усны зардал	11,415,897.00	13,266,623.40
2105	Нормативт зардал	140,016,800.00	158,289,300.00
210502	Хоол, хүнс	140,016,800.00	158,289,300.00
2106	Эд хогшил урсгал засвар	9,639,000.00	13,000,000.00
210604	Урсгал засвар	9,639,000.00	13,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын, үйлчилгээний төлбөр, хураамж	3,870,900.00	5,926,436.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	3,870,900.00	5,926,436.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	31,592,106.00	40,551,710.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,581,806.00	29,249,500.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	12,010,300.00	11,302,210.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,435,615.68	12,692,282.72
	Бусад урсгал шилжүүлэг	24,020,500.00	9,465,200.00
	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	24,020,500.00	9,465,200.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,415,115.68	3,227,082.72
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,415,115.68	3,227,082.72

3	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	113,977,115.48	(219,365,003.77)
5	Хөрөнгө оруулалтын мөнгөн зарлагын дүн		(1,399,800.00)
22	Хөрөнгийн зардал	-	(1,399,800.00)
2200	Дотоод эх үүсвэрээр		(1,399,800.00)
223001	Бусад хөрөнгө	25,079,900.00	(1,399,800.00)
6	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(25,079,900.00)	-
8	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	88,897,215.48	(220,764,803.77)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	155,136,093.27	244,033,308.75
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	244,033,308.75	23,268,504.98

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны үр дүн
А	1	2	3	4
2024 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	249,182,000.00	70,951,414.05	1,904,158,854.41	2,224,292,268.46
НББ-ийн бодлогын өөрчлөлт				-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл				-
ҮХ-ийн өсөлт, бууралт				-
ҮХ-ийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Тайлант үеийн үр дүн			108,202,359.87	108,202,359.87
2025 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	249,182,000.00	70,951,414.05	2,012,361,214.28	2,332,494,628.33
НББ-ийн бодлогын өөрчлөлт				-
ҮХ-ийн өсөлт, бууралт				-
ҮХ-ийн дахин үнэлгээний бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Тайлант үеийн үр дүн			(199,471,494.25)	(199,471,494.25)
2022 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	249,182,000.00	70,951,414.05	1,812,889,720.03	2,133,023,134.08

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
1	ТАТААС, САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО	1,164,052,200.00	1,160,825,117.28	(3,227,082.72)	99.7
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,109,058,700.00	1,109,058,700.00	-	100
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,109,058,700.00	1,109,058,700.00	-	100
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	54,993,500.00	51,766,417.28	(3,227,082.72)	94.1
132001	Орон нутгийн төсвөөс	54,993,500.00	51,766,417.28	(3,227,082.72)	94.1
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	244,033,308.75	-	(244,033,308.75)	-
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	244,033,308.75	-	(244,033,308.75)	-
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,408,085,508.75	1,163,275,117.28	(244,810,391.47)	82.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,411,139,900.00	1,384,039,921.05	(27,099,978.95)	98.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,401,674,700.00	1,374,574,721.05	(27,099,978.95)	98.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	998,054,300.00	993,879,602.79	(4,174,697.21)	99.6
210101	Үндсэн цалин	648,989,400.00	639,065,786.84	(9,923,613.16)	98.5
210102	Нэмэгдэл	312,740,400.00	276,310,487.90	(36,429,912.10)	88.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	38,619,000.00	38,619,000.00	-
210104	Урамшуулал	36,324,500.00	39,884,328.05	3,559,828.05	110
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	123,726,200.00	122,761,454.98	(964,745.02)	99.2
210201	Тэтгэврийн даатгал	83,921,200.00	82,956,090.98	(965,109.02)	98.9
210202	Тэтгэмжийн даатгал	9,951,300.00	9,951,262.50	(37.50)	100
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,975,600.00	4,975,631.25	31.25	100
210204	Ажилгүйдлийн даатгал	4,975,600.00	4,976,046.83	446.83	100
210205	Эрүүл мэндийн даатгал	19,902,500.00	19,902,423.42	(76.58)	100
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	52,828,100.00	38,766,417.28	(14,061,682.72)	73.4
210301	Гэрэл, цахилгаан	15,993,800.00	14,260,012.36	(1,733,787.64)	89.2
210302	Түлш, халаалт	20,432,700.00	11,239,781.52	(9,192,918.48)	55
210303	Цэвэр, бохир ус	16,401,600.00	13,266,623.40	(3,134,976.60)	80.9
2105	Нормативт зардал	164,172,700.00	158,289,300.00	(5,883,400.00)	96.4
210502	Хоол, хүнс	164,172,700.00	158,289,300.00	(5,883,400.00)	96.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,000,000.00	13,000,000.00	-	100
210604	Урсгал засвар	13,000,000.00	13,000,000.00	-	100
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,117,800.00	5,926,436.00	(191,364.00)	96.9
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,117,800.00	5,926,436.00	(191,364.00)	96.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	43,775,600.00	41,951,510.00	(1,824,090.00)	95.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	32,473,100.00	30,649,300.00	(1,823,800.00)	94.4
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,302,500.00	11,302,210.00	(290.00)	100
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,465,200.00	9,465,200.00	-	100
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,465,200.00	9,465,200.00	-	100

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,465,200.00	9,465,200.00	-	100
2	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	1,411,139,900.00	1,384,039,921.05	(27,099,978.95)	98.1
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	244,033,308.75	244,033,308.75	-
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	23,268,504.98	23,268,504.98	-
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100
3	Төсвийн байгууллага	1	1	-	100
5	АЖИЛЛАГСАДЫН ТОО	39	39	-	100
6	Удирдах ажилтан	1	1	-	100
7	Гүйцэтгэх ажилтан	25	25	-	100
8	Үйлчлэх ажилтан	13	13	-	100

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн нийт 6,574.8 мянган төгрөгийн зөрчилд¹ төсвийг хохиролгүй болгох 837.6 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, зөрчлийг таслан зогсоох 5,737.2 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлээ.

5.1 Төлбөрийн акт

5.1.1. Илрүүлэлт: Тус цэцэрлэгийн бараа үйлчилгээний бусад зардлаас хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан эрхлэгч С.Болортуяагийн сургалтын төлбөрт 600.0 мянган төгрөг төлж, батлагдсан төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 39 дүгээр тогтоолоор баталсан “Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам”-ын хавсралт “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хэмжээний бүрэлдэхүүн, зардлын зориулалт, эдийн засгийн ангиллын дэлгэрэнгүй заавар”-ын 3-д “Багшийн хөгжил буюу мэргэжил дээшлүүлэх зардалд цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны хөгжих хэрэгцээнд суурилсан цахим платформд түшиглэн явуулах тусгай сургалт (1, 5, 10 жилийн сургалтаас бусад), бусад сургалт үйл ажиллагааны зардал багтана” гэж заасантай тус тус нийцэхгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

5.1.2. Илрүүлэлт: Тус цэцэрлэгийн эрхлэгч С.Болортуяад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцан ажилласны нэмэгдэл цалин хөлсийг гүйцэтгэсэн ажил үүрэгт нь тохирох цалин хөлсийг олгоогүйгээс нийт 237.6 мянган төгрөг илүү олгож, төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах” 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Хөдөлмөрийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1-д “Ажил олгогч нь ажилтантай тохиролцсоноор ажил хослон гүйцэтгүүлэх, эзгүй байгаа ажилтны үүргийг түр орлон гүйцэтгүүлэх, ажилтны ажлын цагт багтаан өөр ажил, албан тушаал хавсран гүйцэтгүүлэх, ажлын ачааллыг нэмэгдүүлэх хэлбэрээр ажиллуулж болно”, 56.2-д “Энэ хуулийн 56.1-д заасны дагуу ажиллах ажилтанд гүйцэтгэх ажил үүрэгт нь тохирох цалин хөлсийг нэмж олгоно” гэж заасантай тус тус нийцэхгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

5.2 Албан шаардлага

5.2.1. Илрүүлэлт: Тайлант онд тус цэцэрлэгийн эрхлэгч С.Болортуяа нь Дархан-Уул аймгийн Боловсролын газрын даргын 2025 оны А/94 дүгээр тушаалыг үндэслэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцан ажилласны нэмэгдэл цалин хөлсөнд нийт 2,619.2 мянган төгрөг авч, хууль тогтоомжийн хүрээнд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д “Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д “Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хяналт тавих үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын захирал /эзэн/, ажил олгогч шууд хариуцна”, 27.6-д “Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтцийн жишиг, ажилтны орон тооны норматив, зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална”, Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/114 дүгээр тушаалын 1.В хэсэгт “Төрийн болон

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

төрийн үйлчилгээний төсвийн байгууллага ажилтны тооноос хамаарахгүйгээр Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг аль нэг ажилтанд хавсран хариуцуулна. Хавсран ажиллуулсан тохиолдолд Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлд заасны дагуу үндсэн ажлын цалингийн 40 хүртэлх хувийн нэмэгдэл хөлс олгоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байгаа тул албан шаардлага хүргүүлэв.

5.2.2.Илрүүлэлт: Тус цэцэрлэгийн нягтлан бодогч Ч.Жигдэлбаамаад Боловсролын сайдын 2025 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 1/3492 тоот албан бичиг, цэцэрлэгийн эрхлэгчийн 2025 оны 09 дугаар сарын 23-ны өдрийн А/13 дугаар тушаалыг тус тус үндэслэн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар "өөрчлөлтгүй" дүгнэлт авсан тул нэг сарын үндсэн цалинг 2 дахин нэмэгдүүлж, 3,118.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон нь төрийн албан хаагчийн үр дүнгийн урамшуулалтай давхардсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4-д "Төрийн албаны тухай хуульд тусгайлан зааснаас өөрөөр төрийн албан хаагчид нэмэгдэл, нэмэгдэл хөлс тогтоохгүй байхыг төсвийн байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн шууд захирагч нарт даалгасугай", "Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 4.8-д "Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн албан хаагчид албан тушаалын сарын үндсэн цалингийн 15 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг сар бүр тооцож, улирал бүр олгоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байгаа тул албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тус цэцэрлэгийн эрхлэгч С.Болортуяад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцан ажилласны нэмэгдэл цалин хөлсийг гүйцэтгэсэн ажил үүрэгт нь тохирох цалин хөлсийг олгоогүйгээс нийт 237,600.00 төгрөг илүү олгож, төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.	1	237.6	1	237.6	-	-	-	-	-	-	-	-
Тус цэцэрлэгийн бараа үйлчилгээний бусад зардлаас хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан эрхлэгч С.Болортуяагийн сургалтын төлбөрт 600,000.00 төгрөг төлж, батлагдсан төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.	1	600.0	1	600.0	-	-	-	-	-	-	-	-
Тайлант онд тус цэцэрлэгийн эрхлэгч С.Болортуяа нь Дархан-Уул аймгийн Боловсролын газрын даргын 2025 оны А/94 дүгээр тушаалыг үндэслэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцан ажилласны нэмэгдэл цалин хөлсөнд нийт 2,619,200.00 төгрөг авч, хууль тогтоомжийн хүрээнд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.	1	2,619.2	-	-	1	2,619.2	-	-	-	-	-	-
Тус цэцэрлэгийн нягтлан бодогч Ч.Жигдэлбаамаад Боловсролын сайдын 2025 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 1/3492 тоот албан бичиг, цэцэрлэгийн эрхлэгчийн 2025 оны 09 дугаар сарын 23-ны өдрийн А/13 дугаар тушаалыг тус тус үндэслэн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар "өөрчлөлтгүй" дүгнэлт авсан тул нэг сарын үндсэн цалинг 2 дахин нэмэгдүүлж, 3,118,000.00 төгрөгийн урамшуулал олгосон нь төрийн албан хаагчийн үр дүнгийн урамшуулалтай давхардсан байна.	1	3,118.0	-	-	1	3,118.0	-	-	-	-	-	-
Дүн	4	6,574.8	2	837.6	2	5,737.2	-	-	-	-	-	-

